



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/24

Эмээлтолгой

Угтах үйлчилгээний журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын “Угтах үйлчилгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй ажиллахыг нийт ажилтнуудад анхааруулсугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Б.Буянхишиг)-т даалгасугай.


ДАРГА



Б.ӨНӨРБАЯР

642516019

Сумын Засаг даргын Тамгын газрын даргын
2025 оны 10 дугаар сарын 30-ны
өдрийн А/24-р тушаалын хавсралт



УГТАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд зөвлөгөө өгөх, мэдээ мэдээллийг танилцуулах, төрийн үйлчилгээний чанар, шуурхай байдалд ахиц гаргах, төрийн албан хаагчдын ажлын байран дээрх бүтээмжийг нэмэгдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр.Нэр томьёо

2.1."Угтах үйлчилгээний ажилтан" -Үйлчлүүлэгчийн угтан авч, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө өгөх, үйлчилгээ авахад нь чиглүүлэх үүрэг бүхий тухай өдрийн жижүүртэй төрийн албан хаагч

Гурав.Чиг үүрэг

3.1.Сумын Засаг даргын Тамгын газраар үйлчлүүлэхээр хүрэлцэн ирсэн иргэн, хуулийн этгээдэд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг хууль тогтоомжийн дагуу хүргэх, нэгж, албан хаагчтай холбож өгөх

3.2.Угтах үйлчилгээний ажилтан өөрийн хариуцсан салбартай холбоотой гарын авлага, таниулах материал, цаг үеийн мэдээлэл хүргэх

3.3.Бичгээр ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг холбогдох албан тушаалтны цахим хаягаар болон гарт нь хүргүүлэх

Дөрөв.Үйлчилгээний горим

4.1."Угтах үйлчилгээний ажилтан" ажлын цаг эхлэхээс өмнө ажилтнуудын ажлын цагийг бүртгэнэ. (08:30-18:00 цаг)

4.2.Угтах үйлчилгээ үзүүлсэн бүртгэлийн дэвтрийг тогтмол хөтлөх

4.3.Үйлчлүүлэгчийг угтан авч, албан тушаал, нэрээ танилцуулж, үйлчилгээ авахаар ирсэн зорилго, уулзах албан тушаалтныг тодруулж үйлчилнэ.

4.4.Эрх зүйн туслалцаа, мэдээлэл зөвлөгөө авах ажилтан байхгүй тохиолдолд тайлбарлах /албан томилолт, ээлжийн амралт, дотоод журамд заасны дагуу чөлөө, өвчтэй гэх мэт/ яаралтай асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлнэ.

4.5.Угтах үйлчилгээний ажилтан үйлчилгээний стандартад нийцэхүйц, албаны хувцас өмссөн байх, албан тушаал, нэрийг байршуулах (энгэрийн тэмдэг)

Тав.Ажилтны эрх, үүрэг

5.1.Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль,

төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журмыг баримтлан, ёс зүйн зөрчилгүй ажиллах

5.2. Угтах үйлчилгээ үзүүлэхдээ харилцааны соёлтой, шуурхай, үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан, хууль тогтоомжид нийцсэн үйлчилгээ үзүүлэх

5.3. Үйлчлүүлэгчийн санал хүсэлтэд тулгуурлан байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд санал боловсруулж, санаачилга гаргах

5.4. Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг яаралтай шийдвэрлэх хүсэлт гаргасан бол холбогдох нэгж, албан тушаалтанд сануулах, шаардлага тавих, шийдвэрлэлтийн явцыг тодруулах

5.5. Ажлын цаг ашиглалтын мэдээг тухайн өдөрт нь байгууллагын удирдлагад танилцуулах

5.6. Угтах үйлчилгээ үзүүлэх ажилтан нь хууль тогтоомжийн мэдлэг, ажлын байрны ур чадвараа дээшлүүлж, үйлчлүүлэгчдэд аль нэг салбарын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх чадварыг эзэмшсэн байх

5.7. Угтах үйлчилгээний ажилтан тухайн өдрийн тайланг нэгтгэн, дараагийн ээлжид хүлээлгэн өгнө.

Зургаа. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

6.1. Үйлчилгээний талаар мэдээлэл авах, гомдол гаргах

6.2. Холбогдох хууль тогтоомжид заасан үйлчилгээ авах

6.3. Өргөдөл, гомдол, хүсэлтийн хариуг шаардах

6.4. Байгууллагын үйлчилгээний журмыг дагаж мөрдөх, албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх

Долоо. Бусад

7.1. Угтах үйлчилгээг хэрэгжүүлж, санал дүгнэлт, ажил сайжруулах үүргийг байгууллагын удирдлага гаргах

7.2. Угтах үйлчилгээ үзүүлэх албан хаагч энэхүү журмыг хэрэгжүүлээгүй, иргэдэд хүндрэл учруулж, ёс зүйн зөрчил гаргасан бол сахилгын шийтгэл хүлээх үндэслэл болно.

7.3. Согтууруулах ундаа хэрэглэсэн үйлчлүүлэгчийг байгууллагад нэвтрүүлэхийг хориглоно.

7.4. Энэхүү журамд тусгаагүй харилцааг холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.